



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН
САН

ОЮУТНЫ ХӨГЖЛИЙН ЗЭЭЛ

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Оюутны хөгжлийн зээлийн журам” шинэчлэн батлагдаж ШУТИС-ийн бакалавр, магистр, докторын сургалтанд суралцаж байгаа дараах шаардлагыг хангасан оюутнуудад “Оюутны хөгжлийн зээл”-ийг сургуулиараа дамжуулан олгоно.

ТАВИГДАХ ШААРДЛАГА

БАКАЛАВР

- Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж 600 болон түүнээс дээш оноо авсан элсэгч байх;
- 2 болон түүнээс дээш курсийн оюутан бол голч дүн 2.8 болон түүнээс дээш оноотой суралцаж байх;
- Тухайн улиралд судалж байгаа хичээлийн кредит 10 доошгүй сонгосон байх;

МАГИСТР

- Бакалаврын дипломын голч дүн 3.2-оос дээш байх;
- 2 болон түүнээс дээш курсийн магистрант бол 3.2 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байх;
- Тухайн улиралд судалж байгаа хичээлийн кредит 10 доошгүй сонгосон байх;

ДОКТОР

- Магистрын дипломын голч дүн 3.2-оос дээш байх;
- 2 болон түүнээс дээш курсийн докторант бол 3.2 болон түүнээс дээш голч дүнтэй суралцаж байх;
- Тухайн улиралд судалж байгаа хичээлийн кредит 10 доошгүй сонгосон байх;

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

Шинээр зээлд орох хүсэлтэй оюутны хувьд

- ✓ Иргэний үнэмлэхийн хуулбар
- ✓ Зээл хүссэн, эргэн төлөхөө илэрхийлсэн өргөдөл
[/http://must.edu.mn/uploads/2018/05/03/urgudul-mayagt-1.pdf](http://must.edu.mn/uploads/2018/05/03/urgudul-mayagt-1.pdf) хаягнаас татаж авч бөглөх/
- ✓ Элсэлтийн ерөнхий шалгалтын батламжийн хуулбар
- ✓ Голч дүнгийн тодорхойлолт
- ✓ Төлбөрийн нэхэмжлэлийн эх хувь
- ✓ Тухайн улиралд судалж байгаа хичээл сонголтын хуудсыг гарын үсэг, тамга дарж баталгаажуулсан байх
- ✓ Ирээдүйн зорилгоо тодорхойлох ЭССЭ
[/http://must.edu.mn/uploads/2018/05/03/essay-zagvar-1.pdf](http://must.edu.mn/uploads/2018/05/03/essay-zagvar-1.pdf) эссэ бичих удирдамжийг татаж авах/

Зээлээ дахин сунгах хүсэлтэй оюутны хувьд

- ✓ Голч дүнгийн тодорхойлолт
- ✓ Төлбөрийн нэхэмжлэлийн эх хувь
- ✓ Тухайн улиралд судалж байгаа хичээл сонголтын хуудсыг гарын үсэг, тамга дарж баталгаажуулсан байх


Зээл хүсэгчид дээрх бичиг баримтыг бүрдүүлж бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд 8 дугаар сарын 20-ноос 09 дүгээр сарын 20-ны дотор, 1 дүгээр сарын 20-ноос 2 дугаар сарын 20-ны дотор өгнө үү.



ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД СУРАЛЦАГЧИЙН ТЭТГЭЛЭГ

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд заасны дагуу дээд боловсролын сургалтын байгууллагын бакалаврын боловсрол эзэмших өдрийн ангид суралцаж байгаа Монгол Улсын иргэн, хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэнд тус тус сургалтын төлбөр, суралцагчийн тэтгэлэг, санхүүгийн дэмжлэгийг олгодог. Дараах тохиолдолд оюутан та суралцагчийн тэтгэлэгт хамрагдах боломжтой болно. Үүнд:

СУРАЛЦАГЧИЙН ТЭТГЭЛГИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ



Холбогдох материалыг жил бүрийн 9 дүгээр сарын 05-ны дотор бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын албанд хүлээн авна.



ШУТИС-ИЙН ОЮУТНУУДАД ОЛГОДОГ КРЕДИТ УРАМШУУЛАЛ

ШУТИС-ийн оюутнуудын нийгмийн идэвхи, оролцоог дээшлүүлэх, тэдний авьяас чадвар, хүсэл сонирхлыг нь урамшуулан дэмжих, хөгжүүлэх зорилгоор сурлага, эрдэм шинжилгээ, урлаг, спортын онцгой амжилт гаргасан шилдэг оюутнуудад урамшуулал олгодог.

ШУТИС-ийн Захирлын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/223 тушаалаар шинэчлэн батлагдсан журмын дагуу бүрэлдэхүүн сургуулийн хүсэлт, холбогдох материалыг Оюутны соёл, үйлчилгээний алба /ШУТИС-ийн төв байрны 1-327 тоот өрөө/-нд хүлээн авна.

КРЕДИТИЙН УРАМШУУЛЛЫН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ

№	Төрөл, үзүүлэлт	Кредит
	Шилдэг суралцагч	
I	<ul style="list-style-type: none">1 улирал 3.6-аас дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан2 улирал дараалан 3.6-аас дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан3 улирал дараалан 3.6-аас дээш үнэлгээний голчтой суралцсан	1 кр хүртэл 3 кр хүртэл 5 кр хүртэл
	Эрдэм шинжилгээний хурал, олимпиад	
II	<ul style="list-style-type: none">Бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээний хурал, олимпиадУлсын чанартай уралдаан, тэмцээнШУТИС-ийн эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиадОлон улсын эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад	2 кр хүртэл 3 кр хүртэл 6 кр хүртэл 6 кр хүртэл
	Мэргэжлийн уралдаан, тэмцээн	
III	<ul style="list-style-type: none">Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд зохиогдсон уралдаан, тэмцээнШУТИС-ийн хэмжээний уралдаан, тэмцээнУлсын чанартай уралдаан, тэмцээнОлон улсын хэмжээний уралдаан, тэмцээн	2 кр хүртэл 3 кр хүртэл 4 кр хүртэл 6 кр хүртэл
	Спортын уралдаан, тэмцээн	
IV	<ul style="list-style-type: none">Их, дээд сургуулиудын оюутны тэмцээнУлсын чанартай тэмцээн, лигийн тэмцээнОлон улсын чанартай тэмцээн	3 кр хүртэл 4 кр хүртэл 5 кр хүртэл



	Соёл, урлагийн уралдаан, тэмцээн	
V	<ul style="list-style-type: none"> • ШУТИС-ийн Урлагийн их наадам • Улсын хэмжээний уралдаан, тэмцээн • Олон улсын хэмжээний соёл, урлагийн уралдаан, тэмцээн 	2 кр хүртэл 3 кр хүртэл 6 кр хүртэл
	Клубийн үйл ажиллагаа	
VI	<ul style="list-style-type: none"> • Клубүүдэд хичээл заадаг оюутнууд • Клубийн ахлагч • Олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог оюутан, клубийн гишүүн 	3 кр хүртэл 2 кр хүртэл 1 кр хүртэл
	Оюутны холбоо, оюутны зөвлөл	
VII	<ul style="list-style-type: none"> • Оюутны холбооны тэргүүн • Ерөнхий нарийн бичгийн дарга • Хяналтын хорооны дарга • Оюутны холбооны гишүүн /4 хүртэлх оюутан/ • Бүрэлдэхүүн сургуулийн оюутны зөвлөлийн дарга • Оюутны зөвлөлийн гишүүн /2 хүртэлх оюутан/ • Оюутны байрны зөвлөлийн дарга • Оюутны байрны зөвлөлийн гишүүдэд /4 хүртэлх оюутан/ 	12 кр хүртэл 8 кр хүртэл 8 кр хүртэл 8 кр хүртэл 10 кр хүртэл 5 кр хүртэл 5 кр хүртэл 3 кр хүртэл





ШУТИС-ИЙН ЗАХИРЛЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ

Оюутнуудын сурч боловсрох идэвхийг дээшлүүлэх, тэдний авьяас чадвар, хүсэл сонирхолыг нь урамшуулан дэмжих, хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, урлаг, спортын онцгой амжилт гаргасан шилдэг оюутнуудыг урамшуулах, амьдралын боломж муутай оюутнуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор амжилттай суралцаж байгаа бакалавр, магистр, доктор оюутнуудыг урамшуулахад оршино.

№	Шалгуур үзүүлэлт	Тэтгэлгийн хэмжээ	Зарлагдах хугацаа	Бүртгүүлэх газар
Шилдэг суралцагч оюутан				
	<ul style="list-style-type: none"> 3.6 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй 2 улирал дараалан суралцсан байх; Олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцож шалгарсан байх; Оюутны эрдэм шинжилгээний ажил, олимпиадад амжилттай оролцож шалгарсан байх; Сайн дурын үйл ажиллагаанд тогтмол үр дүнтэй оролцсон байх Оюутны бусад тэтгэлэгт хамрагдаагүй байх; 	30 хүртэлх кредит	Жил бүрийн 12 сар	Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба
Шилдэг элсэгч оюутан				
	<ul style="list-style-type: none"> Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой өрхийн суралцагч байх; Монгол улсын тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр элсэн суралцагч байх; Бүрэлдэхүүн сургуульд өндөр оноогоор элссэн орсон суралцагч байх; 	30 хүртэлх кредит	Жил бүрийн 8-9 сар	Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба
Шилдэг төгсөгч оюутан				
	<ul style="list-style-type: none"> Үнэлгээний голч дүн 3.2 ба түүнээс дээш байх; Эрдэм шинжилгээ, сурлага, урлаг, спортоор шилдэг төгсөгч байх; Шинэ санаа, үр дүнг хэвлэн нийтлүүлсэн техник технологийн ололт амжилтыг хэрэглээнд нэвтрүүлсэн байх; Сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагаанд тогтмол үр дүнтэй оролцож, зохион байгуулсан байх; 	100.0 мян. төгрөг	Жилд 12, 05-р сар	Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба
Коосен Технологийн Коллеж				
	<ul style="list-style-type: none"> Олон улс болон улсын чанартай олимпиадын гурав, дөрвийн даваанд амжилттай оролцож шагналт байранд орсон байх; Улсын чанартай олимпиадын хоёрын даваанд амжилттай оролцож шагналт байранд орсон байх; 3.20 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй 2 улирал дараалан суралцсан, санхүүгийн хувьд дэмжлэг авах шаардлагатай суралцагч байх; 	50-100% хүртэлх сургалтын төлбөр	Жил бүрийн 8-9 сар	Бүрэлдэхүүн сургуулийн Сургалтын алба

Бүрдүүлэх бичиг баримт:

- Анкет /онлайнаар анкет бөглөх/
- Иргэний үнэмлэхний хуулбар /нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/
- Сургуулийн болон дүнгийн албан ёсны тодорхойлолт /Нийт суралцсан хугацааны голчийг улирал түс бүрээр гарган, дэд захирлаар баталгаажуулах/
- Сургуулийн дэлгэрэнгүй тодорхойлолт
- Хорооны тодорхойлолт /гэр бүлийн гишүүдийн тоо, өрхийн орлогын тухай мэдээллийг багтаасан байх/
- Үзүүлсэн амжилтуудын гэрчилгээ, сертификат, өргөмжлөлийн хуулбар /нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/

Жич: 1-р курсын оюутнууд Элсэлтийн Ерөнхий шалгалтын батламжийн хуулбарыг авчрах, сүүлийн 2 жилийн амжилтыг хавсаргаж болно. Төгсөх курсын оюутнууд зөвхөн оюутан байх хугацаанд үзүүлсэн амжилтыг хавсаргана.

Эхний шатны шалгаруулалтыг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж хурлын протоколын хамт холбогдох материалыг Оюутны соёл, үйлчилгээний алба /ШУТИС-ийн төв байрны 1-327 тоот өрөө/-нд зарлагдсан хугацаанд багтаан ирүүлнэ.





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОЛОН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ

Мэдлэг боловсрол, бүтээлч чанар, шинэ санаа, сайн үйлс, авъяас, ур чадварыг хөгжүүлэх, урамшуулан дэмжих зорилгоор үлгэр жишээ онцгой амжилт гаргасан дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагын бакалаврын хөтөлбөрийн өдрийн ангийн оюутан, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв (цаашид "сургууль" гэнэ)-ийн суралцагч (цаашид "суралцагч" гэнэ)-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг (цаашид "тэтгэлэг" гэнэ) олгоход энэхүү журмыг баримтална.

Дараах шалгуур үзүүлэлтүүдийг 50-иас дээш хувьтай хангасан суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг олгоно. Үүнд:

- Хичээлийн жилийн 4 улирал дараалан голч дүн нь 3.6-аас доошгүй үнэлэгдсэн байх;
- Нийгмийн сайн сайхны төлөөх сайн дурын үйл ажиллагаанд тогтмол үр дүнтэй оролцож, зохион байгуулж, олон нийтэд мэдээлэгдсэн байх;
- Суралцаж байгаа мэргэжлийн чиглэлээрээ олон улсын болон үндэсний хэмжээнд судалгаа хийж үнэлүүлсэн, шинэ санаа, үр дүнг хэвлэн нийтлүүлсэн, техник технологийн ололт амжилтыг хэрэглээнд нэвтрүүлсэн байх;
- Монголын уламжлалт ёс заншил, угийн бичиг хөтлөх болон бусад үйл хэргийг өөрийн амьдралдаа хэвшүүлэн дадлагажуулж бусдад үлгэрлэсэн байх.

Дараах шалгуур үзүүлэлтийг 50-иас дээш хувьтай хангасан суралцагчид Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгоно. Үүнд:

- Монгол Улсын тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр (2014 оны 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан) үр ашиг, ач холбогдол бүхий шинэ технологи, бүтээгдэхүүн, материал бий болгон үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх шинэ санаачилга гаргасан байх;
- Сайн санааны үндсэн дээр нийгмийн сайн сайхны тусын тулд бусдыгаа манлайлан идэвхи зүтгэл гаргаж үлгэр жишээ болохуйц ажлыг санаачлан зохион байгуулсан, эерэг өөрчлөлтөөр бусдадаа үлгэр дуурайл болсон байх;
- Монгол хэл, соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулан түүнийг өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлсэн байх;
- Суралцаж байгаа мэргэжлээрээ амжилттай суралцаж бусдад үлгэр дуурайл болсон, улс орны хөгжилд эерэг үр нөлөө үзүүлэхүйц судалгаа, шинжилгээний бүтээл туурвисан, оновчтой үр дүнтэй бодлого төлөвлөгөө, зөв шийдэл, арга барил бүхий нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөл, хөтөлбөр санаачлан бичиж хэрэгжүүлсэн;

Материал хүлээн авах, шалгаруулалт

Болзлыг хангасан оюутан өөрөө буюу сургуулийн захиргаа, оюутны байгууллага нь хамтарч тухайн суралцагчийг тэтгэлэгт нэр дэвшүүлнэ.

Тэтгэлэгт нэр дэвшигчийн дор дурдсан бичиг, баримтыг жил бүрийн 4 ба 11 дүгээр сарын 15-ны дотор сургуулийн оюутны холбоо нь шалгаруулж, болзол хангасан оюутнуудын материалыг Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ.



Бүрдүүлэх материал

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигчийн мэдүүлэг (2 дугаар хавсралт);
- Болзлыг хангасан суралцагч нь сурлагын амжилт, ур чадвараа баталгаажуулсан сургуулийн захиргааны болон оюутны холбооны тодорхойлолт, гэрчилгээ, батламжийн хуулбар, бичиж хэрэгжүүлсэн төслийн үр дүнгийн тухай танилцуулга;
- Хэвлүүлсэн илтгэл, өгүүллийн хувь, медаль, шагнал, өргөмжлөл, гэрчилгээ, патент болон тухайн шинэ технологи, бүтээгдэхүүн материалыг хүлээн зөвшөөрсөн салбарын эрх бүхий байгууллагын шийдвэрийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- Холбогдох арга хэмжээ, олон нийтийн ажлыг хамтран зохион байгуулсан байгууллагын тодорхойлолт, тухайн арга хэмжээний зорилго зорилт, үр дүнгийн талаар холбогдох мэдээлэл, дүрс бичлэг, фото зураг;
- Хадгалан хамгаалж, өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлж байгаа уламжлалт ёс заншил, ургийн бичиг, соёлын биет болон биет бус өвийн талаархи богино хэмжээний танилцуулга, дуут ба дүрс бичлэг, түгээн дэлгэрүүлж байгааг нотлох бусад материалууд;
- Оюутан өөрөө 500 үгэнд багтаан эссэ;

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН НЭРЭМЖИТ ШАГНАЛ

“Шилдэг оюутанд Зам, тээврийн хөгжлийн сайдын нэрэмжит шагнал олгох журам”-ын дагуу Зам, тээврийн салбарын мэргэжлээр дотоод, гадаадын их дээд сургуульд амжилттай суралцаж, судалгаа, шинжилгээний ажил, шинэ бүтээл, оновчтой саналыг дэвшүүлсэн суралцагчид “Шилдэг оюутанд Зам, тээврийн хөгжлийн сайдын нэрэмжит шагнал”-ыг олгоно.

Тавигдах шаардлага

- Хоёр болон түүнээс дээш дамжааны оюутан байх
- Оюутны голч дүн нь 3,6-аас доошгүй байх
- Суралцаж байгаа мэргэжлийн чиглэлээрээ дотоод гадаад эрдэм шинжилгээний хуралд оролцсон, тодорхой амжилт гаргасан байх
- Суралцаж байгаа мэргэжлээрээ амжилттай суралцаж бусдад үлгэр дуурайл үзүүлсэн зам тээврийн салбарын хөгжилд үр нөлөө үзүүлэхүйц судалгаа, эрдэм шинжилгээний ажил, шинэ бүтээл, оновчтой саналыг дэвшүүлсэн төсөл, хөтөлбөр санаачлан бичиж олон нийтэд танилцуулсан байх
- Суралцаж буй чиглэлээрээ Олон улсын уралдаан тэмцээнд оролцож шагналт байранд шалгарсан, оюутны шинэ бүтээл гаргаж оюутны өмчийн патентаар баталгаажсан мөн шинэ бүтээл нь үйлдвэрлэлд нэвтэрч эдийн засгийн үр ашиг бий болгосон бол дээрх заалтуудыг харгалзахгүйгээр шалгаруулалтанд оролцуулна.

Материал хүлээн авах хугацаа

- Сайдын нэрэмжит шагналд нэр дэвшүүлэгчийн мэдүүлэг
 - Оюутны голч дүн, сурлагын амжилт, эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажил түүний үр дүнг баталгаажуулсан сургуулийн захиргааны тодорхойлолт
 - дотоод, гадаадын уралдаан, тэмцээнд эрдэм шинжилгээний бүтээл судалгааны ажлын чиглэлээр оролцож шагнагдаж байсан бол түүнийг нотлох баримт материалын хуулбар;
 - Шинэ бүтээл туурвиж оюуны өмчийн патент авсан бол баталгаажуулсан хуулбар
 - Шинэ бүтээл нь үйлдвэрлэлд нэвтэрсэн бол тухайн үйлдвэр аж, ахуйн газрын тодорхойлолт
- Журамд заасны дагуу шаардлага хангасан оюутныг Сайдын нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, холбогдох материалыг бүрдүүлж жил бүрийн 1 дүгээр сарын 05-ны дотор Оюутны соёл, үйлчилгээний алба (ШУТИС-ийн Төв байрны 327 тоот өрөө)-нд ирүүлнэ.





ШУТИС-ИЙН ОЮУТНУУДАД ОЛГОДОГ ГАДНЫ БАЙГУУЛЛАГЫН НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ

№	Байгууллагын нэр	Зарлагдах хугацаа	Тавигдах ерөнхий шаардлага	Бүртгүүлэх газар
1	ШУТИС-Тоёота сангийн тэтгэлэг	Жил бүрийн 9-10 сар	<ul style="list-style-type: none">- 4 улирал дараалан амжилттай суралцаж буй бакалавр түвшний оюутан байх;- Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, сургалтын төлбөрийн хувьд санхүүгийн дэмжлэг шаарлагатай оюутан байх;- Онцгой авьяастай, техник сэтгэлгээтэй, эрдэм шинжилгээний хурал, урлаг спортын арга хэмжээнд идэвхитэй оролцдог бол давуу тал болно.	ШУТИС-ийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба
2	Мицубиши корпорацийн нэрэмжит тэтгэлэг	Жил бүрийн 9-10 сар	<ul style="list-style-type: none">- ШУТИС-д амжилттай суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний оюутан байх;- Бакалаврын оюутны хувьд 2,3,4-р курст суралцдаг байх;- Сургалтын үнэлгээний голч 3,2-оос дээш байх;- Сургалтын төлбөрийн хувьд санхүүгийн дэмжлэг авах шаардлагатай байх;- Эрдэм шинжилгээний хурал, урлаг спортын арга хэмжээнд идэвхитэй амжилттай оролцдог байх;	ШУТИС-ийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба
3	Сүмитомо корпорацийн нэрэмжит тэтгэлэг	Жил бүрийн 2-3 сар	<ul style="list-style-type: none">- ШУТИС-д амжилттай суралцаж буй бакалаврын түвшний оюутан байх;- Монгол улсын 30-аас доош насны иргэн байх;- Зээл болон өөр ямар нэгэн тэтгэлэгт хамрагдаагвй байх;- Сурлагын үнэлгээний голч дүн 3.0-оос дээш голчтой байх;	ШУТИС-ийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба
4	ПОСКО ТиЖи Парк сангийн тэтгэлэг	Жил бүрийн 6-р сар	<ul style="list-style-type: none">- ШУТИС-д амжилттай суралцаж буй бакалавр түвшний оюутан байх;- Бакалаврын оюутны хувьд 1, 2, 3-р курст суралцдаг байх. 4-р курсын оюутнуудын хувьд өмнө нь тус сангийн тэтгэлэгт хамрагдаж байсан тохиолдолд шалгаруулалтад оролцох эрхтэй.- Сурлагын үнэлгээний голч 3,0-оос дээш байх;- Сургалтын төлбөрийн хувьд санхүүгийн дэмжлэг авах шаардлагатай байх;- Эрдэм шинжилгээний хурал, урлаг спортын арга хэмжээнд идэвхитэй амжилттай оролцдог байх;	ШУТИС-ийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба





“ТОЁОТО-ШУТИС” СУРГАЛТЫН САНГИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Монгол, Япон улсын хамтын ажиллагааны хүрээнд 1998 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Япон улсын Тоёота Корпораци болон Техникийн их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулсан. “Тоёота-Мотор корпораци”-аас ШУТИС-д хандивласан хөрөнгөөр “ТОЁОТО-ШУТИС” Сургалтын санг үүсгэн байгуулсан бөгөөд сурлага, сахилга батаар тэргүүний, амьдралын боломж муутай, төлбөрийн чадамжгүй оюутнуудыг сурч боловсрох боломжоор нь хангахад тус тэтгэлгийн гол зорилго оршидог.

Тавигдах шаардлага:


- ШУТИС-д амжилттай суралцаж буй бакалаврын 3,4-р курсын оюутан байх;
- 3,2-оос дээш голч дүнтэй байх; /4 улирал дараалан амжилттай суралцсан байх/
- Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, сургалтын төлбөрийн хувьд санхүүгийн дэмжлэг шаарлагатай оюутан байх;
- Онцгой авьяастай, техник сэтгэлгээтэй, эрдэм шинжилгээний хурал, олимпиад, мэргэжлийн уралдаан, тэмцээн, урлаг спортын арга хэмжээнд идэвхитэй оролцдог байх;

Бүрдүүлэх материал:

- Анкет
- Иргэний үнэмлэхний хуулбар /нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/;
- Профессор багшийн тодорхойлолт;
- Сургуулийн болон дүнгийн албан ёсны тодорхойлолт /нийт суралцсан хугацааны голчийг улирал түс бүрээр гарган дэд захирлаар баталгаажуулах/
- Хорооны тодорхойлолт /гэр бүлийн гишүүдийн тоо, өрхийн орлогын тухай мэдээллийг багтаана/
- Гэрчилгээ, сертификат, өргөмжлөлийн хуулбар /нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/

Жич: Зөвхөн оюутан байх хугацааны амжилтыг тусгасан байх

Анкет болон холбогдох материалыг ШУТИС-ийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба /ШУТИС-ийн төв байрны 2 давхарт 218 тоот/-д хүлээн авна.





Sumitomo Corporation

"СУМИТОМО КОРПОРАЦИ"-ИЙН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР

Азийн хөгжиж буй улс орнуудын ирээдүйн лидер болох шилдэг оюутнуудыг дэмжихэд энэ тэтгэлгийн зорилго оршино.

"Сумитомо Корпораци"-ийн тэтгэлэг олгоход баримтлах зvйл:

- Нэг жилд нийт 20 оюутанд тэтгэлэг олгох бөгөөд нэг оюутанд олгох тэтгэлгийн хэмжээ жилд 1,000,000 төгрөг байна.
- Нэг оюутанд 4 жил хүртэлх хугацаанд тэтгэлэг олгох бөгөөд жил бүр суралцсан байдлыг шалган, 3.0-оос дээш голч дүнтэй суралцсан тохиолдолд тэтгэлгийг сунгах бололцоотой.
- Эхний шатны шалгаруулалт ШУТИС дээр зохион байгуулах бөгөөд оюутны бүрдүүлсэн материал, тавигдах шаардлага, эссэ бичсэн байдлыг харгалзан үзнэ. Эцсийн шалгаруулалтыг "Сумитомо корпораци"-ийн Монгол дахь албан ёсны төлөөлөгчийн газраас хийх бөгөөд оюутны бүрдүүлсэн материал, эссэ болон ярилцлагын дүнг харгалзана.
- Зөвхөн эхний шатанд тэнцсэн оюутантай холбогдон ярилцлагын цагийг зарлана.

Тавигдах шаардлага:

- ШУТИС-ийн бакалаврын өдрийн ангийн 1 болон 3-р курсын оюутан байх;
- 30-аас доош насны Монгол улсын иргэн байх;
- Зээл болон бусад ямар нэгэн тэтгэлэгт хамрагдаагүй байх;
- Сурлагын үнэлгээний голч дүн 3.0 буюу түүнээс дээш байх;
- Санхүүгийн хувьд зайлшгүй дэмжлэг авах шаардлагатай байх;
- Аливаа хэрэг зөрчилд холбогдож байгаагүй байх;

Бүрдүүлэх бичиг баримт:

- Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах хүсэлт, эссэ /Эссэг өөрийн сонгосон сэдвийн дагуу бичнэ.
- Иргэний үнэмлэхний хуулбар /нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/
- Сургуулийн болон дүнгийн албан ёсны тодорхойлолт /Нийт суралцсан хугацааны голчийг улирал түс бүрээр гарган, дэд захирлаар баталгаажуулах/
- Хорооны тодорхойлолт /гэр бүлийн гишүүдийн тоо, өрхийн орлогын тухай мэдээллийг багтаасан байх/.
- Үзүүлсэн амжилтуудын гэрчилгээ, сертификат, өргөмжлөлийн хуулбар /нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/
- 3-р курсын оюутнууд зөвхөн оюутан байх хугацаанд үзүүлсэн амжилтыг хавсаргана.

Жич: 1-р курсын оюутнууд Ерөнхий боловсролын гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулан авчрах, сүүлийн 2 жилийн амжилтыг хавсаргаж болно.

Тэтгэлэг үргэлжлүүлэн авах оюутнуудын хувьд:

- Албан ёсны дүнгийн тодорхойлолт

Материалыг ШУТИС-ийн Төв байрны 2 давхарт 218 тоотод /Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба/-д хүлээн авна.





МИЦУБИШИ КОРПАРАЦИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Дэлхийн 90 орчим улсад 200 гаруй салбар нэгжтэй Японы тэргүүлэх зэргийн худалдааны компани болох Мицубиши Корпараци нь бакалавр, магистр, докторын түвшний оюутны сургалтын төлбөрийн тэтгэлгийг олгодог. Энэхүү тэтгэлгийн зорилго нь Монгол улсын нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, ирээдүйтэй шилдэг оюутнуудыг дэмжихэд оршино.

Ерөнхий зарчим:

- Нийт 8 оюутанд /бакалавр-6, магистрант, докторант-2/ тэтгэлэг олгох бөгөөд тэтгэлгийн хэмжээ оюутан тус бүрд 1,000,000 төгрөг байна.
- Материал илгээж буй оюутан бүр өгөгдсөн сэдвийн дагуу эссэ бичнэ.
- Эхний шатны шалгаруулалт ШУТИС дээр явагдах бөгөөд оюутны бүрдүүлсэн материал, тавигдах шаардлагууд, эссэг харгалзан шалгаруулна.
- Эцсийн шалгаруулалтыг Мицубиши Корпарацийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газарт явуулах бөгөөд оюутны бүрдүүлсэн материал болон эссэг харгалзан шалгаруулдаг.

Тавигдах шаардлага:

- ШУТИС-д амжилттай суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний оюутан байх;
- Бакалаврын оюутны хувьд 2,3,4-р курст суралцдаг байх;
- Сурлагын үнэлгээний голч 3,2-оос дээш байх;
- Сургалтын төлбөрийн хувьд санхүүгийн дэмжлэг авах шаардлагатай байх;
- Эрдэм шинжилгээний хурал, урлаг спортын арга хэмжээнд идэвхитэй, амжилттай оролцдог байх;

Бүрдүүлэх материал:

- Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах хүсэлт, эссэ
 - Иргэний үнэмлэхний хуулбар
 - Сургуулийн болон дүнгийн албан ёсны тодорхойлолт /нийт суралцсан хугацааны голчийг улирал түс бүрээр гарган дэд захирлаар баталгаажуулах/
 - Хорооны тодорхойлолт /гэр бүлийн гишүүдийн тоо, өрхийн орлогын тухай мэдээлэлийг багтаана/
 - Багшийн тодорхойлолт /оюутны талаар холбогдох салбар, тэнхимийн эрхлэгч, профессор, зөвлөх багшийн аль нэгнээс тодорхойлолт авах/
 - Гэрчилгээ, сертификат, өргөмжлөлийн хуулбар /нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/
- Жич: Оюутан байх хугацааны амжилтыг тусгасан байх /Бакалаврын 2-р курсын оюутнууд сүүлийн 3 жилийн амжилтыг тусгасан байж болно./*

Материалыг ШУТИС-ийн Төв байрны 2 давхарт 218 тоотод /Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба/-д хүлээн авна.





БНСУ-ЫН "POSCO TJ PARK" САНГИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Бүгд Найрамдах Солонгос Улсын "POSCO TJ PARK" сан нь 6 дах жилдээ бакалавр оюутны сургалтын төлбөрийн тэтгэлгийг нийт 10 бакалавр оюутанд тэтгэлэг олгох бөгөөд тэтгэлэгийн хэмжээ оюутан тус бүрт 700 ам.доллар байна.

Тавигдах шаардлага:

- ШУТИС-д амжилттай суралцаж буй бакалавр түвшний 1, 2, 3-р курст суралцдаг байх;
- Сурлагын үнэлгээний голч 3,0-оос дээш байх;
- Сургалтын төлбөрийн хувьд санхүүгийн дэмжлэг авах шаардлагатай байх;
- Эрдэм шинжилгээний хурал, урлаг спортын арга хэмжээнд идэвхитэй амжилттай оролцдог байх;
- Зээл болон бусад ямар нэгэн тэтгэлэгт хамрагдаагүй байх нь давуу тал болно

Бүрдүүлэх материал:

- Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах хүсэлт
 - Иргэний үнэмлэхний хуулбар /нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/
 - Сургуулийн болон дүнгийн албан ёсны тодорхойлолт /нийт суралцсан хугацааны голчийг улирал түс бүрээр гарган, дэд захирлаар баталгаажуулах/
 - Хорооны тодорхойлолт /гэр бүлийн гишүүдийн тоо, өрхийн орлогын тухай мэдээллийг багтаасан байх/
 - Гэрчилгээ, сертификат, өргөмжлөлийн хуулбар /нотариатаар баталгаажуулах шаардлагагүй/
- Жич: Зөвхөн оюутан байх хугацаанд үзүүлсэн амжилтыг хавсаргана. 1-р курсын оюутнууд сүүлийн 2 жилийн амжилтыг хавсаргаж болно

Тэтгэлэг үргэлжлүүлэн авах оюутнуудын хувьд:

- Албан ёсны дүнгийн тодорхойлолт /Дэд захирлаар баталгаажуулах/

Материалыг ШУТИС-ийн Төв байрны 2 давхарт 218 тоотод /Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба/-д хүлээн авна.

